



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/692

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2, 6.8.2, 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх заалтууд, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3.1 дэх заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2 дахь хэсгийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алсын хараа-2050, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг иргэд олон нийтэд сурталчлах, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн санал авах зорилгоор олон нийтэд хандсан контент бүтээх, орон нутгийн телевизүүдээр нэрвтрүүлэхээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу 6,0 сая төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 6,0 сая төгрөг /Зургаан сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
11 дүгээр сарын 11-ний өдрийн
А/692 дугаар захирамжийн хавсралт



МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГА, ЯРИЛЦЛАГА, РЕКЛАМ
СУРТАЛЧИЛГАА ХИЙЛГЭХ ЗАРДАЛ

| д/д | Хийгдэх ажил | Нэг бүрийн үнэ | Тоо ширхэг | Нийт үнэ |
|-----|--|----------------|------------|-----------|
| 1 | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны Үндсэн чиглэлийн нэвтрүүлэг, мэдээ, сурвалжлага, ярилцлага, реклам сурталчилгаа хийлгэх | 3 000 000 | 2 | 6 000 000 |
| ДҮН | | | | 6 000 000 |

-oOo-